

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 16-ны өдрийн А/693 дугаар захирамж, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2022 оны 11 сарын 22-ны өдрийн 1/22 дугаар удирдамжийн дагуу Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр, Ж.Оюун нар 2022 оны 11 сарын 22-ны өдрөөс 2022 оны 12 сарын 05-ны өдрийг дуусталх хугацаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Булган аймаг дахь ХАА-н МСҮТөвийн 2020, 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2010 онд үүсгэн байгуулагдсан. 100 хувь төрийн өмчит сургууль юм.

Тус төв нь дараах мэргэжлээр төрөлжсөн мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд орон нутгийн бодлого хөтөлбөрүүдтэй сургалтын үйл ажиллагааг уялдуулан явуулж байна.

Мэргэжлийн боловсролын сургалт, чиглэл:

- Ойжуулагч – 2.5 жил, 1 жил
- Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан - 2.5 жил, 1 жил
- Жимс, жимсгэний аж ахуйн фермер - 2.5 жил, 1 жил
- Хүнсний ногооны фермер - 2.5 жил, 1 жил
- Хүлэмжийн аж ахуйн фермер - 2.5 жил, 1 жил
- ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин - 2.5 жил, 1 жил
- Тракторын механик - 1 жил
- Малын асаргаа - 1 жил
- Фермерийн аж ахуй эрхлэх - 1 жил
- Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэх - 1 жил
- Малчин – 1 жил

Булган сумын дөрөвдүгээр багт байрлах 3187179 регистрийн дугаартай ХАА-н МСҮТөвд 2020-2021 оны хичээлийн жилд 140 оюутан суралцсан. 2021-2022 оны хичээлийн жилд шинээр 146 суралцагч элсэж, 9 мэргэжлээр 176 суралцагч суралцсан байна.

2020 онд захирал, сургалтын албаны менежер, арга зүйч, хүний нөөц гадаад худалдаа хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан захиралын туслах, сахиул, жолооч, үйлчлэгч, нярав, номын санч, нягтлан бодогч, багш 18, дотуур байрны багш 3, тогооч 2, слесарь цахилгаанчин, галч 4 нийт 39 орон тоотойгоор, 2021 онд захирал, Захиргаа аж ахуйн менежер, Сургалтын албаны менежер, Арга зүйч багш, Мэргэжлийн багш 11, Ерөнхий эрдмийн багш 2, Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан, Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ажилтан, Нийгмийн түншлэл хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик хариуцсан арга зүйч, Цахим сургалтын агуулга, хөгжүүлэлт, сургалтын нөөц хариуцсан ажилтан, Цахим тоног төхөөрөмж хариуцсан ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, Дотуур байрны багш 2, Номын санч, Нягтлан бодогч, Захирлын туслах архив бичиг хэргийн ажилтан, Тогооч, гал тогооны туслагч, Нярав, Слесарь цахилгаанчин, Жолооч, Дотуур байрны жижүүр, Үйлчлэгч, Сахиул, Галч 4 нийт 40 орон тоотойгоор төрөлжсөн мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаагаа хүргэсэн байна.

ХАА-н МСҮТөвийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 01 сарын 01-нээс 12 сарын 31-ний өдрийг хүртэл Н.Пүрэвсайхан, 2-р гарын үсгийг 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 02 сарын 29-ний өдрийг хүртэл Э.Нямдорж, 03 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл Т.Ариунбат нар, 2021 онд 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг Н.Пүрэвсайхан, хоёрдугаар гарын үсгийг Т.Ариунбат нар зурсан ба аймгийн төрийн санд бүртгэлийн 100040037021 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040037402 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг “Си Ти Эс” программаар бүртгэн хөтөлж, цалин хөлс, шагнал урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тайланг Сангийн яамны цалингийн нэгдсэн системээр тайлагнаж иржээ.

Нярав, эд хариуцагчаар С.Мягмарсүрэн ажиллажээ.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газар, 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК гүйцэтгэж “**зөрчилгүй**” санал дүгнэлт өгсөн байна.

ХАА-н МСҮТөвийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан хаагчдын цалингийн нэмэгдлийг 1-4-р сард ажилласан хугацаанд ногдсон цалингаас бодоогүй ажиллавал зохих цалингаас тооцож 345.1 мянган төгрөгийн цалин илүү олгосонд төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

2021 онд төлбөрийн акт тогтоогдоогүй, групптэй ажилтанд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон, үндсэн хөрөнгийн дансанд 3,927.0 мянган төгрөгийн 20 ширхэг мэдээллийн самбар бүртгэгдсэн эдгээр 2 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгсөн ба үүний хэрэгжилтийг албан тоотоор хүргүүлсэн байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2020 онд төсөв гүйцэтгэл цэс 49 мэдээлэл оруулахаас 48 мэдээллийг хуулийн хугацаанд, 1 мэдээллийг хугацаа хоцроож, хөрөнгө оруулалт тендер худалдан авалт цэсэнд 39 мэдээллээс 38 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол бусад цэсний 61 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

2021 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 161 мэдээллийг ил тод хуулийн хугацаанд мэдээлж, байршуулсан байна.

ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Булган аймаг дахь ХАА-н МСҮТөвийн 2021 оны касс, харилцах, үндсэн хөрөнгө, хүнс, бараа материалын баримт, төсвийн шууд захирагчийн А, Б тушаал, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, цагийн бүртгэл, цалингийн карт, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, дотоод хяналтын тайлан илтгэх хуудас, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн баримт бичиг, аудитын тайлан зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан захирал Н.Пүрэвсайхан, нягтлан бодогч Т.Ариунбат, нярав С.Мягмарсүрэн нарыг байлцуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэв.

7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2020 онд төсөвт зардлыг 652,399.6 мянган төгрөгийн санхүүжилтээр төсөв баталсанаас 649,399.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 3,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсөвөөс 637,852.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,700.4 мянган төгрөг нийт 640,552.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цалинд 313,961.7 мянган төгрөг, хоолны хөнгөлөлт 8,390.4 мянган төгрөг ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл илүү цагийн нэмэгдэлд 69,816.3 төгрөг, үр дүнгийн үрамшуулалд 31,811.6 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 51,031.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал гэрэл цахилгааны төлбөр 5,909.6 мянган төгрөг, түлш халаалтын зардал 26,653.4 мянган төгрөг, цэвэр, бохир ус 2,524.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16,238.5 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэлд 718.6 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 850,0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3,369.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 12,088.1 мянган төгрөг хоол хүнсэнд 9,924.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 85,570.7 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Хэмнэгдсэн зардлыг дэлгэрэнгүйгээр харуулбал: Цалингийн зардлаас 62,802.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 14,684.1 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 6,563.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 1,520.3 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмнэлт өндөр гарсан нь нийт албан хаагчдын ажил

олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг 13.5 хувиар төлөхөөр тооцоолсон боловч 12.5 хувиар төлсөнтэй холбогдон хэмнэлт үүссэн байна. Цалингийн хэмнэлт үүссэн нь 2020 онд корона вирусын өвчлөл гарсантай холбогдуулан хорио цээрийн үед хичээл сургалтыг цахимаар өгөх болсон учир багш нарын багц цагийн олголт, сар бүр илүү цагийн нэмэгдлийг олгоогүйтэй холбоотойгоор хэмнэгдсэн байна.

Урсгал засварт 3,369.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд сургуулийн спорт заалны будгийн ажлын зардалд 420.0 мянган төгрөг, уурын зуухны дээвэр, хаалгыг засварлах 910.1 мянган төгрөг, дотуур байрны шавардлага, цонхны дулаалга хийхэд 1,077.3 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэл худалдан авахад 180.4 мянган төгрөг, заалны сангийн зардалд 781.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Цалин урамшууллын талаар:

ХАА-н МСҮТ-ийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/27 тоот тушаалаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улирлын ажлын үр дүнг үндэслэн 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг 16 албан хаагчид 15-30 хувиар үнэлэн 2,681.1 мянган төгрөгийг, 18 багшийн ажлыг 15-35 хувиар үнэлэн 3,206.5 мянган төгрөгийг, ХАА-н МСҮТ-ийн Захирлын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/39 тоот тушаалаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улирлын ажлын үр дүнг үндэслэн 15 албан хаагчид 5-40 хувиар үнэлэн 2,119.8 мянган төгрөгийг, 16 багшийн ажлыг 20-40 хувиар үнэлэн 4,097.9 мянган төгрөгийг 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд, 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/47 тоот тушаалаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улирлын ажлын үр дүнг үндэслэн 14 албан хаагчид 10-40 хувиар үнэлэн 2,719.7 мянган төгрөгийг, 15 багшийн ажлыг 12-40 хувиар үнэлэн 3,467.1 мянган төгрөгийг 3 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд, 12 дугаар сарын 16-ны өдрийн А/75 тоот тушаалаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улирлын ажлын үр дүнг үндэслэн 16 албан хаагчид 17-42 хувиар үнэлэн 3,719.7 мянган төгрөгийг, 17 багшийн ажлыг 17-45 хувиар үнэлэн 4,135.9 мянган төгрөгийг 4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд тус тус олгосон байна.

Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 04 сарын 5-ны өдрийн А/93 дугаар тушаалаар ХАА-н МСҮТ-ийн захирлын ажлын тайланг үнэлэн 1 дүгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг үндсэн цалингаас сар бүр 15 хувиар тооцон 448,1 мянган төгрөгийг, 2020 оны 06 сарын 26-ны өдрийн А/160 дугаар тушаалаар ХАА-н МСҮТ-ийн захирлын ажлын тайланг үнэлэн 2 дугаар улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг үндсэн цалингаас сар бүр 15 хувиар тооцон 448,1 мянган төгрөгийг олгосон байна.

ХАА-н МСҮТ-ийн захирлын 12 сарын 02-ны өдрийн А/68 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилийн “Малын асаргаа-3А”, “Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан-3А” мэргэжлийн ангийн суралцагчдын төгсөлтийн үнэлгээний багийг байгуулж, өвлийн төгсөлтийн үнэлгээний ажлын хэсэгт ажилласан 10 багш, ажилтанд цагийн тооцоо 1,688.4 мянган төгрөгийг олгосон байна.

Захирлын 2020 оны 12 сарын 16-ны өдрийн А/76 тоот тушаалаар 2020 оны шилдэг ажилтнаар слесарь, цахилгааны ажилтан Б.Алтангэрэлийг шалгаруулж нэг сарын үндсэн цалин 506,4 мянган төгрөгөөр шагнасан байна.

ХАА-н МСҮТ-ийн Захирлын 2020 оны 12 сарын 16-ны өдрийн А/77 тоот тушаалаар цар тахлын улмаас улс даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Мэргэжлийн байгууллагаас иргэдийг дархлаагаа байнга

дэмжих зөвлөмжтэй холбогдуулан багш ажилтнуудад нэг удаагийн дэмжлэг үзүүлэхэд 1,517.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ур чадварын нэмэгдлийн талаар:

ХАА-н МСҮТ-ийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/11 тоот тушаалаар 01 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг 35 багш ажилтанд 10-25 хувиар тооцон 3,839.5 мянган төгрөгийг, 2 сарын 18-ны өдрийн А/21 тоот тушаалаар 2 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 35 ажилтанд 10-20 хувиар үнэлэн 4,140.5 мянган төгрөгийг, 3 сарын 20-ны өдрийн А/26 тоот тушаалаар 2 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 11 ажилтанд 10-25 хувиар үнэлэн 1,144.6 мянган төгрөгийг, 3 сарын 20-ны өдрийн А/27 тоот тушаалаар багш ажилтнуудын 1 улирлын мөнгөн урамшууллыг 16 албан хаагчид 15-30 хувиар үнэлэн 2,681.1 мянган төгрөг, 18 багш нарт 15-35 хувиар үнэлэн 3,206.5 мянган төгрөгийг, 4 сарын 21-ний өдрийн А/32 тоот тушаалаар 4 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг 15 ажилтанд 10-25 хувиар үнэлэн 1,611.1 мянган төгрөгийг, 5 сарын 25-ны өдрийн А/35 тоот тушаалаар 5 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 19 ажилтанд 5-20 хувиар үнэлэн 2,789.1 мянган төгрөгийг, ХАА-н МСҮТ-ийн Захирлын 2020 оны 6 сарын 17-ны өдрийн А/38 тоот тушаалаар 6 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 14 ажилтанд 10-25 хувиар үнэлэн 1,651.7 мянган төгрөгийг, 7 сарын 01-ний өдрийн А/41 тоот тушаалаар 7 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 8 ажилтанд 15-25 хувиар үнэлэн 994,1 мянган төгрөгийг, 8 сарын 25-ны өдрийн А/43 тоот тушаалаар 8 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 13 ажилтанд 15-25 хувиар үнэлэн 1,127.9 мянган төгрөгийг, 9 сарын 21-ний өдрийн А/46 тоот тушаалаар 9 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг 12 ажилтанд 15-25 хувиар үнэлэн 1,443.7 мянган төгрөгийг, 10 сарын 16-ны өдрийн А/51 тоот тушаалаар 10 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 18 ажилтанд 10-25 хувиар үнэлэн 1,703.8 мянган төгрөгийг, 11 сарын 20-ны өдрийн А/63 тоот тушаалаар 11 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг 13 ажилтанд 10-25 хувиар үнэлэн 1,305.8 мянган төгрөгийг, 12 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 20 ажилтанд 15-25 хувиар үнэлэн 2,307.3 мянган төгрөгийг олгосон байна.

2021 онд улсын төсвөөс 711,598.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,000.0 мянган төгрөг нийт 714,598.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан төсөвт - өөрчлөлт оруулан 690,102.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 687,102.7 мянган төгрөг, орон сууц түрээслэсний төлбөр 981.2 мянган төгрөг, цалингийн урьдчилгааны хувь хүнээс авах авлагын 150.0 мянган төгрөг, 2020 оны жилийн эцэст дотуур байрны суралцагчдын хоолонд хэрэглэхээр нөөцөлсөн үхрийн мах 517.9 кг үлдсэнийг албан хаагчид худалдан борлуулсаны орлого 4,445.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1,828.2 мянган төгрөг нийт 694,507.3 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, үйл ажиллагааны зардалд 647,231.8 мянган төгрөгийг зарцуулж, 47,275.5 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд албан хаагчид 7,650.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосныг бүрэн суутгасан байна.

Ур чадварын нэмэгдлийг сар бүр, улирлын үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгосон байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт-	Төсвийн нийт зардалд эзлэх хувь
2101	Цалин өлс болон нэмэгдэл урамшил	458,782.9	434,191.3	+24,591.6	67.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,715.8	57,648.0	+8,067.8	8.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,698.7	31,547.3	+151.4	4.9
2104	Хангамж, бараа материалын зардал	12,812.6	12,780.5	+32.1	2.0
2105	Нормативт зардал	19,275.6	9,495.4	+9,780.2	1.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,433.2	23,431.5	+1.7	3.6
2107	Томилолт, зочны зардал	121.0	0	+121.0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,020.0	896.6	+123.4	0.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,974.4	18,973.2	+1.2	2.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,268.5	58,268.0	+0.46	9.0
	Дүн	690,102.7	647,231.8	42,870.6	100

Ковид 19 цар тахлын хорио цээрийн үед цахим хичээлд шилжсэнтэй холбоотойгоор үндсэн багшийн орон тоо дутуу, багш нарын танхимын болон танхимын бус цагийн нэмэгдэл сар бүр олгогдоогүй, 1-6, 9-р саруудад суралцагчид дотуур байранд байрлаагүй тул хоолны зардал болон бусад төсөвт зардал хэмнэгдэхэд нөлөөлжээ.

Нэмэлт төсөв: 2020, 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Дотоод аудитын талаар:

2020 онд Хөдөлмөрийн сайдын хяналт үнэлгээ шинжилгээ, дотоод аудитын тайлангийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, зөвлөмжийг биелэлийг хангаж ажилласан. Дотуур байрны орчин нөхцөлийг тодорхойлох, өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, шинэ санал санаачлагын хүрээнд хийгдсэн ажлын үр дүн, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, 2020 оны 1 дүгээр улирлын мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тооцсон үнэлгээнд болон шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр улирлын хэрэгжилтийн байдалд дотоод аудит, хяналт шинжилгээ, монотиринг хийсэн байна.

2021 онд санхүү бүртгэлийн чиглэлээр дотоод хяналтыг хийсэн байна. Үүнд: **1.** Няравын анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтөлсөн эсэх, барилга байгууламжийн хувийн хэрэг, техник ашиглалтын пастортын хөтлөлтийг тухай бүр тэмдэглэсэн эсэх, эд хариуцагчийн картын хөдөлгөөн хийсэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах материалыг цаг тухай бүр хүлээлтгүйгээр зохион байгуулсан байдал, тайлан мэдээг хугацаанд нь гаргасан байдал, **2.** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2021 оны 1-10-р сарын байдлаар шалгасан **3.** 1-10-р сард олгосон ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу

олгосон эсэх, 2020 оны ур чадварын нэмэгдлийг шалгасан зөвлөмжийн хэрэгжилт 4. Улирлын мөнгөн урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон эсэх 5. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг 2021 оны 3-р сарын байдлаар тооцох.

Уг хяналтаар тайлан өгөөгүй, тайланг дүгнэхгүйгээр ажилтанд ур чадварын нэмэгдэл олгодог, мөн тайлан өгөөгүй ажилтанд улирлын урамшуулал олгосон, шилэн дансны цахим хуудсанд бүтэц орон тооны мэдээлэлд сул орон тоог тусгаагүй дутуу мэдээлсэн, уг мэдээллийн хүснэгтийг бүрэн бөглөж тайлагнаагүй, номын санд хандиваар ирсэн ном, гарын авлагын ашиглалтын хугацааг тогтоогоогүй, нярав тайланг нягтлан бодогчид хугацаа хоцроон өгдөг, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, барилга ашиглалт, авто машины бүртгэл хөтлөлтийг нэгбүрчлэн хөтлөх байдал хангалтгүй, хүнсний бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтлөлтүүд хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрсэнд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Оюутан суралцагчдын хувьсах зардлын талаар: Дотуур байр 50 оюутны хүчин чадалтай ба дунджаар 2020 онд давхардсан тоогоор 2560 оюутан байрлаж хоолны зардалд 7,160.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2021 онд тус төвийн дотуур байранд 62 оюутан хүлээн авах хүчин чадалтай, 2021-2022 оны хичээлийн жилд дотуур байранд 34 суралцагч амьдрахаар бүртгэгдсэн, гүйцэтгэлээр 2021 онд 10-р сарын 01-ний өдрөөс 12-р сарын 24-ний өдрийг хүртэл нийт 80 өдөр өдөрт дунджаар 10 суралцагч амьдарч 770 хүүхэд өдөрт 2,501.3 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна. Дэлгэрэнгүй харуулбал: 10 сарын 01-ний өдрөөс 10 сарын 26-ны өдрийг хүртэл 26 өдөр ажиллаж 236 хүүхэд өдөрт 707.2 мянган төгрөгийн, 11 сарын 01-ээс 11 сарын 30-ны өдрийг хүртэл 30 өдөр ажиллаж 247 хүүхэд өдөрт 930.7 мянган төгрөгийн, 12 сарын 01-ээс 12 сарын 24-ний өдрийг хүртэл 24 өдөр ажиллаж 287 хүүхэд өдөрт 863.5 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан.

Худалдан авах ажиллагааны талаар: Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 1 сарын 7-ны өдрийн А/02 тоот тушаалаар үнэлгээний хороог байгуулсан байна. 2020-2021 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан түүний дагуу дотуур байрны суралцагчдын хоол, хүнсний материал нийлүүлэх тендерийг холбогдох хуулийн дагуу зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, гүйцэтгэгчээр 02 сарын 11-ны өдрөөс “Анхдагч Аян” ХХК-тай гэрээ байгуулан хүнс материалыг худалдан авсан байна.

Захирлын 2020 оны 09 сарын 15-ны өдрийн худалдах, худалдан авах гэрээгээр халаалтын шаардлага хангасан шаталт, илчлэг сайтай, элдэв хорт үнэргүй нүүрсийг худалдан авахаар “Арвин ган Бумба” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.

2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд дотуур байрны хүүхдийн хоол, хүнс батлагдсан төсөв-35,867.0 мянган төгрөг, түлш халаалт – 28,162.4 мянган төгрөг нийт 64,029.4 мянган төгрөгийн бараа худалдан авахаар тусгаж, баталсан байна. ХАА-н МСҮТөвийн захирлын 2021 оны 01 сарын 08-ны өдрийн А/03 дугаар тушаалаар дотуур байрны суралцагчдын хоол хүнсний материал, түүхий эд,

халаалтын зуухны нүүрс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Хүнсний материал, нүүрс нийлүүлэх тендерийг холбогдох хуулийн дагуу зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, дотуур байрны хүүхдийн хоолны материал, түүхий эд бэлтгэн нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Очир шонхор” ХХК-ийг сонгон, худадах худалдан авах гэрээг 2021 оны 03 сарын 22-ны өдөр, түлш халаалтын нүүрсийг бэлтгэн нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Арвин ган Бумба” ХХК-ийг сонгон, худадах худалдан авах гэрээг 2021 оны 03 сарын 19-ний өдөр тус тус байгуулсан байна. Очир шонхор ХХК-иас 4,076.5 мянган төгрөг (*үхрийн мах 145кг*9500төгрөг+200кг*10,000 төгрөг нийт 3,377.5 мянган төгрөгөөр, бусад хүнсний материалыг 699.0 мянган төгрөгөөр авсан*)-өөр хүнсний материал, “Арвин ган Бумба” ХХК-иас нэг тонн нүүрсийг 100.0 мянган төгрөгөөр тооцож 238 тн нүүрс 23,800.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Мөн Захирлын 2021 оны 11 сарын 16-ны өдрийн А/49 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо “дотуур байрны суралцагчдын төмөр ор хийлгэх” гүйцэтгэгчээр Булган сумын иргэн Б.Энх-Эрдэнийг сонгож, шууд гэрээ байгуулан 10,000.0 мянган төгрөгөөр 25 ширхэг давхар төмөр ор хийлгүүлсэн байна.

Түрээсийн төлбөр: ХАА-н МСҮТөвийн 84м² талбайтай 3 өрөө орон сууц /галлагаатай/-ыг тус сургуулийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан У.Идэрбуянд 2021 оны 01 сарын 02-ны өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд, сургалтын менежер Н.Жаргалсайханд 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд тус тус сарын түрээсийн төлбөрийг 44.6 мянган төгрөгөөр тооцон түрээслүүлэхээр гэрээ байгуулсан байна. У.Идэрбуянгийн 1-10-р сарын цалингаас орон сууцны түрээсийн төлбөрт /2021 оны 11 сарын 04-ний өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн/ 446.0 мянган төгрөг, Н.Жаргалсайханы 1-12-р сарын цалингаас орон сууцны түрээсийн төлбөрт 535.2 мянган төгрөг нийт 981.2 мянган төгрөгийг суутгаж сургуулийн үндсэн дансанд (100040037021 тоот данс/ шилжүүлсэн байна.

7.2 Өглөг, авлагын талаар:

2020 онд тус байгууллага нь өмнөх оны жилийн эцэст ажиллагсад болон хувь хүнээс авах авлага 5,026.1 мянган төгрөгийг авлагатай гарсан ба тайлант хугацаанд ажиллагсадтай холбоотой Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2,719.5 мянган төгрөг, ХХОАТатвартай холбоотой авлага 2,156.6 мянган төгрөг нийт 4,876.1 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, хувь хүнээс авах авлага 150.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. Тайлант онд байгууллага хооронд болон хувь хүмүүст өглөг үүсгээгүй ажилласан байна.

2021 онд өглөггүй. Авлагын хувьд 2018 онд үүссэн цалингийн урьдчилгааны хувь хүнээс авах 150.0 мянган төгрөг, тайлант онд дотуур байрны суралцагчдын хоолны хүнсний материалын үлдэгдлээс байгууллагын ажиллагсад худалдан борлуулсан үхрийн махны 4,445.2 мянган төгрөг нийт 4,595.2 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулж, оны эцэст авлагагүй тайлан баланс гаргасан байна.

7.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

2020 онд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,146,357.5 мянган төгрөгийн хөрөнгө дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөрөнгө оруулалтаар 27,692.0 мянган

төгрөгийн тавин морины хүчтэй трактор, 53,077.0 мянган төгрөгийн зуун морины хүчтэй трактор, 127,415.0 мянган төгрөгийн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, 7,183.0 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг принтер, 1 ширхэг зурагт, 24,011.0 мянган төгрөгийн хүлэмж, тоног төхөөрөмж, 1,774.6 мянган төгрөгийн ном нийт 241,152.6 мянган төгрөгийн хөрөнгө ирсэнийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, оны эцэст 2,387,510.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2021 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	1,521,192,436.83	546,689,955.00	59,213,635.00	2,008,668,756.83
2	Авто- тээврийн хэрэгсэл	159,214,145.87	37,500,000.00	78,445,145.87	118,269,000.00
3	Машин тоног төхөөрөмж	430,526,655.38	14,026,275.00	72,973,534.00	371,579,396.38
4	Тавилга, эд хогшил	91,308,180.00	49,731,790.00	66,685,880.00	74,354,090.00
5	Номын фонд	8,457,187.00	7,154,912.00	4,002,930.00	11,609,169.00
6	Бусад үндсэн хөрөнгө	24,655,000.00	0.00	644,000.00	24,011,000.00
7	Программ хангамж	16,418,500.00	0.00	15,918,500.00	500,000.00
8	Бусад биет бус хөрөнгө	135,738,000.00	0.00	0.00	135,738,000.00
	Дүн	2,387,510,105.08	655,102,932.00	297,883,624.87	2,744,729,412.21

Нийт **13,377.8** мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн. Үүнд: Чиглэл тоног төхөөрөмж ХХК-иас 708.0 мянган төгрөгөөр аяга таваг хатаагч, 385.0 мянган төгрөгөөр дээжийн жижиг хөргөгч, Номин бизнес клуб ХХК-иас 529.99 мянган төгрөгөөр хивс угаагч, Булган Анар ХХК-иас 700.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, 209.8 мянган төгрөгөөр хоёр ширэмтэй индукцин плетика, Булган аураг ХХК-иас 500.0 мянган төгрөгөөр дөрвөн метрийн урттай сунадаг шат (солонгос), Булган сумын иргэн Б.Энх-Эрдэнээс 10,000.0 мянган төгрөгөөр 25 ширхэг хоёр давхар төмөр ор /дотуур байрны суралцагчдын/, Ю Си Эдү групп ХХК-иас 75.0 мянган төгрөгөөр “Мэргэжлийн боловсролын цуврал” ном 3 ширхэг, Замын хөдөлгөөн судлалын хүрээлэнгээс 60.0 мянган төгрөгөөр “Замын хөдөлгөөний дүрэм” 10 ширхэг ном, 150.0 мянган төгрөгөөр “Замын хөдөлгөөний дүрэм тест” ном 10 ширхэг”, иргэн Г.Мартаас 60.0 мянган төгрөгөөр “Хөдөө аж ахуйн мэргэжлийн ангийн лавлах толь” ном 1 ширхэг үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд ХАА-н мэргэжлийн ангиудын дадлагын барилгын засвар, халаалтын зуухны өргөтгөл, малын бага эмчийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, багшийн хөгжлийн төвд гурван үйлдэлт принтер зэрэг нийт 564,063.2 мянган төгрөгийн хөрөнгө бий болсон, ирсэнийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан орлогод тусгаж, тайлагнажээ.

№	Үндсэн хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн	/мянган төгрөг/
					Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагын нэр
1	Хөдөө аж ахуйн мэргэжлийн ангиудын дадлагын барилгын засвар (Хүлэмжийн аж ахуйн фермер”, “Малын асаргаа” мэргэжлийн ангийн дадлагын	1	278,848.6	278,848.6	ХНХЯ-Ворк мастер ХХК

	зориулалтаар өвлийн хүлэмж болон малын бага эмчийн лаборатори, онолын танхим) /капиталжуулсан/				
2	Өвлийн нарлаг хүлэмж /20x8 м/	1	175,782.7	175,782.7	ХНХЯ-Ворк мастер ХХК
3	Уурын зуухны тогоо ком	1	67,033.6	67,033.6	ХНХЯ-Ворк мастер ХХК
4	Малын бага эмчийн лабораторит багаж, тоног төхөөрөмж /12 нэр төрөл/	28		26,117.0	ХНХЯ-Грийн химистри ХХК
5	Гурван үйлдэлт принтер	1	4,397.4	4,397.4	ХНХЯ-Саммит компьютер технологи ХХК
6	Принтер /HP Laserjet Pro M404dn загварын/	1	874.0	874.0	Саммит компьютер технологи ХХК
7	Угаалгын машин /Smart/	1	470.0	470.0	Ургац хангай ХХК
8	Сандал /Багшийн хөгжлийн төвд/	12	35.0	420.0	Оффис тавилга дэлгүүр
9	Ширээ /Багшийн хөгжлийн төвд/	1	830.0	830.0	Оффис тавилга дэлгүүр
10	Ширээ /Багшийн хөгжлийн төвд/	12	110.0	1,320.0	Оффис тавилга дэлгүүр
11	Эвхдэг хар сандал	15	64.0	960.0	Оффис тавилга дэлгүүр
12	Хурлын индэр	1	200.0	200.0	Оффис тавилга дэлгүүр
13	Ном, гарын авлага /55 нэр төрөл/	1712		6,809.9	Эдмон принт ХХК
				564,063.2	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 06, 2021 оны 05 сарын 11-ний 135, 2021 оны 11 сарын 11-ний 502 дугаар тогтоолуудыг үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 48 нэр төрлийн 169,137.6 мянган төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж нийт үнийг 77,661.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож дахин үнэлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 13, 2021 оны 05 сарын 11-ний 141, 2021 оны 05 сарын 11-ний 521 дугаар тогтоолуудыг үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, ашиглалтын хугацаанд сэргээн засварлах боломжгүй болсон, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 114 нэр төрлийн 128,746.0 мянган төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан.

7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2020 онд эхэнд бараа материалын үлдэгдэл 155,629.9 мянган төгрөг байсан дээр төсвийн хөрөнгөөр 65,141.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр эм боох материалд 1,450.5 мянган төгрөг, аж ахуйн материалд 32,923.6 мянган төгрөгийн материал хүлээн авч, 53,066.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, захирлын тушаалаар 4,797.8 мянган төгрөгийн бараа материалыг актан данс бүртгэлээс хасч, оны эцэст 197,280.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлан баланс гаргасан байна.

2021 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл

1	Бичиг хэрэг	665,900.00	1,956,770.00	2,167,810.00	454,860.00
2	Аж ахуйн материал	32,947,800.00	6,875,600.00	4,357,600.00	35,465,800.00
3	Түлш, шатах тослох	5,899,200.00	26,899,807.00	32,568,007.00	231,000.00
4	Сэлбэг хэрэгсэл	8,708,986.00	0.00	500,000.00	8,208,986.00
5	Хоол, хүнс	5,827,152.00	4,076,500.00	6,946,467.00	2,957,185.00
6	Эм, боох материал	1,618,500.00	568,791.00	963,591.00	1,223,700.00
7	Барилгын засвар	55,000.00	11,071,700.00	11,126,700.00	
8	Тусгай зориулалт	26,568,351.00	13,722,850.00	13,203,878.00	27,087,323.00
9	Бусад хангамж	114,989,973.34	8,426,144.00	32,850,163.00	90,565,954.34
	Дүн	197,280,862.34	73,598,162.00	104,684,216.00	166,194,808.34

2021 онд төсвийн хөрөнгө 69,715.2 мянган төгрөгөөр бараа материал худалдан авсан, 70,322.7 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, жилийн эцэст 166,194.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлан баланс гаргасан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд малын бага эмчийн лабораторит 42 нэр төрлийн 177 ширхэг 2,098.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл ирсэнийг аж ахуйн материалын тайланд, байгууллагын багш, ажиллагсдын шинэ санал санаачлага ажлын хүрээнд 1,785.0 мянган төгрөгөөр 21 ширхэг ажлын хувцас оёулж бусад хангамжийн материалын дансанд тус тус нийт 3,883.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр орлогод авсан.

ХАА-н МСҮТөвийн захирлын 2021 оны 04 сарын 28-ны А/25, 2021 оны 12 сарын 28-ны А/62 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1, 31.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 2.1.1 дэх заалт, Өмч хамгаалах зөвлөлийн 2021 оны 04 сарын 27, 2021 оны 12 сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн сургалтын хэрэгцээнд ашиглах, засаж сэлбэх боломжгүй, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын хугацаа дууссан нийт 134 нэр төрлийн 695 ширхэг 18,788.2 мянган төгрөгийн бараа материалыг тус тус актлан, данс бүртгэлээс хассан.

2021 оны эхэнд 33 нэр төрлийн 5,827.2 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байсан ба үүнээс ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор суралцагчид цахимаар хичээллэх болсоноос 8600 төгрөгийн нэгжийн үнэтэй үхрийн мах 430 кг, 8500 төгрөгийн нэгжийн үнэтэй үхрийн мах 87.9 кг нийт 4,445.2 мянган төгрөгийн 517.9 кг үхрийн махыг багш, ажиллагсдад дансны үнээр худалдан борлуулсан байна.

Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ч байгууллагын даргын тушаалгүйгээр бараа материалын дансанд бүртгэлтэй 11,128.2 мянган төгрөгийн бараа материал /байгууллагын үйл ажиллагаанд ашигласан, хэрэглээд дууссан ч данс бүртгэлд бүртгэлтэй байсан гэж аж ахуйн материалын данснаас 3 нэр төрлийн 25 ширхэг 3,692.0 мянган төгрөгийн, тусгай зориулалтын материалын данснаас 257.4 мянган төгрөгийн, бусад хангамжийн материалын данснаас 7,178.8 мянган төгрөгийн/ -ыг данснаас хасч тайлагнажээ.

ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Тус байгууллага нь дадлагад суурилсан, үйлдвэрлэлтэй хосолсон сургалтын системийг хэрэгжүүлж өнөөгийн нийгэм, зах зээл, аж үйлдвэрлэл хэрэгцээтэй хөдөө аж ахуйн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Мөн санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан, төсвийн хөрөнгөөр болон хандив, үнэ төлбөргүйгээр ирсэн хөрөнгийг тухай бүрд нь орлогод авч данс бүртгэлд тусгасан, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж актаар баталгаажуулсан, эд хариуцагч бүртэй хөрөнгө, бараа материалын тооцоог бодож хэвшсэн, харилцахын болон аж ахуйн баримт материалыг эмх цэгцтэй үдэж архивласан, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг сайн хэрэгжүүлсэн, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 48 нэр төрлийн 169,137.6 мянган төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг дахин үнэлж байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа зэрэг дэвшилттэй тал нилээдгүй байна.

ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ

2020 онд илэрсэн зөрчил:

1. Анхан шатны баримтуудын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/-д заасныг;

2. 1-3 сард олгосон шатахуун олголтын хуудас байхгүй, шаардахаар шатахууныг зарцуулаагүй нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1./Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заалт, 13.4 /Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/ заалтыг,

3. Жолоочийн замын хуудсанд явсан спидометрийн заалт бичигдээгүй, шатахууныг олгосон хэмжээгээр зарцуулсан нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн 390 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй.

2021 онд илэрсэн зөрчил: Агуулахын бүртгэл хөтөлдөггүй, шаардах хуудсыг дугаарлаагүй, эд хөрөнгийн тооллогын комисст бүртгэлийн программаас үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлийг хэвлэн гаргаж, тоолуулдаг, тооллогын комисс тооллогоор бэлэн тоологдсон хөрөнгө, материалыг нэгтгэж “тооллогын бүртгэл” гаргаагүй, программаас гаргасан тооллогын бүртгэлд гарын үсэг зурсан, орлогын баримтыг нэг хувь үйлддэг, тушаалаар акталсан номыг нэр төрөл, тоо ширхэгээр нь бус нийт үнийн дүнгээр “номнууд” гэж нийт үнийн дүнгээр данс бүртгэлээс хассан зэрэг зөрчлүүд илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягт, зааврыг мөрдөж ажиллаагүй байна.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын ахлах байцаагчийн 3 актаар 327.6 мянган төгрөгийн төлбөр тогтоов. Үүнд:

1. Ээлжийн амралтын олговортой давхардуулан 2 албан хаагчид 69.0 мянган төгрөгийн цалин олгосныг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх

2. Дутуу олгосон ур чадварын нэмэгдлийн 27.1 мянган төгрөгийн 1 албан хаагчид нөхөн олгох
3. Нэр бүхий 3 албан хаагчийн цалинг буруу тооцоолсоноос 231.5 мянган төгрөгийн цалин илүү олгосныг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх

Санхүү, бүртгэлийн 2 албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ДҮГНЭЛТ

ХАА-н МСҮТөвийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтууд эмх цэгцтэй, анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг оновчтой төлөвлөж, дотоод хяналтын чанар үр нөлөөг дээшлүүлэн илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар холбогдох албан тушаалтан, ажилтанд хугацаатай үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон, удирдлагад танилцуулан хариуцлага тооцох санал хүргүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан эд хөрөнгийн үнийн мэдээлэл, урсгал засвар зэрэг зардлын мэдээллийг ил тод байдлын самбарт мэдээлж байх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, төлбөрийн актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАТТУЛГА

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

А.АНХБАЯР
Ж.ОЮУН

